# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 28 өдөр Дугаар 427 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэрийн, нийт 55,867,212.00 (тавин таван сая найман зуун жаран долоон мянга хоёр зуун арван хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанид худалдах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13205946

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын ...08.....-ны өдрийн
......427....... дугаар тогтоолын хавсралт

"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Насос СД-160/45 | 3/28/2003 | 1 | ш | 1,884,680.00 | 1,884,680.00 |
| 2 | Халаах гадаргуу өрлөг дулаалга К4 | 12/19/2006 | 1 | ш | 51,711,382.00 | 51,711,382.00 |
| 3 | Трансформатор 160кВа /АТП-1/ | 1/1/1984 | 1 | ш | 569,000.00 | 569,000.00 |
| 4 | Шит КНС | 10/12/2007 | 1 | ш | 560,000.00 | 560,000.00 |
| 5 | А3 өнгөт принтер | 12/31/2017 | 1 | ш | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 6 | Факс | 12/31/2013 | 1 | ш | 142,150.00 | 142,150.00 |
| Нийт дүн | | | 6 | | 55,867,212.00 | 55,867,212.00 |
| | | | (зургаа) | | (тавин таван сая найман зуун жаран долоон мянга хоёр зуун арван хоёр) | (тавин таван сая найман зуун жаран долоон мянга хоёр зуун арван хоёр) |